



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**
**JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY**



**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн
нийгмийн оролцоог дэмжих
төсөл (DPUB)**

Мэдээллийн эмхэтгэл No.22

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг
хамгаалах өдрийн Үндэсний чуулганд оролцож
илтгэл тавилаа. (2018.12.07)**

12-р сарын 3-ны Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад төр, төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх нь” сэдэвт Үндэсний чуулган зохион байгуулагдлаа. Энэ үеэр DPUB төслийн зүгээс “Монгол улсын ололт амжилт, тулгамдаж буй асуудлыг олон улсын өнцгөөс харахад” сэдвээр илтгэл тавилаа. Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах үндэсний зөвлөл, дэд зөвлөл, салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байгаа нь олон улсад өндрөөр үнэлэгдэх үйл ажиллагаа юм. Харамсалтай нь дээрх зөвлөлүүдийн хэрэгжүүлж буй ажил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үр дүнтэй оролцоо хараахан хангалтгүй байгаа бөгөөд энэ талаар төслийн илтгэлд дурдлаа. Гэхдээ DPUB төсөл хэрэгжиж эхэлснээс хойшхи 2 жил хагасын туршлагаас харахад Монгол Улсын Засгийн газар, ХБИ-ийн ТББ-ууд цаашид эдгээр асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ажиллана гэдэгт итгэлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог хангах үндэсний зөвлөл байгуулагдаад 2 жил л өнгөрсөн байгаа учраас хойшид үйл ажиллагаа нь жигдэрч, илүү эрчимжинэ гэж бодож байна. ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр холбогдох хууль эрхзүйн орчин бүрдэж, хэрэгжилт хангагдана гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд ЖАЙКА-ийн зүгээс ч гэсэн Монгол Улсын Засгийн газар, ХБИ-ийн ТББ-уудтай хамтран ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.

*Үндэсний чуулгантай холбоотой мэдээллийг доорх цахим хуудсуудаас унших боломжтой.

- <https://ikon.mn/n/1g4p...>
- <http://www.medee.mn/main.php...>
- <http://www.montsame.mn/mn/read/173159...>
- <https://www.facebook.com/eaglenewsocial/videos/370100727059882/>

**Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах семинар зохион байгуулагдлаа.
(2018.11.19)**

Та бүхэн зураг дээрх хэт огцом налуу замыг ямар хүмүүс хэрэглэдэг гэж бодож байна вэ? →

Улаанбаатар хот дахь хэн ч хэрэглэдэггүй хэт огцом налуу замуудыг арилган, бүх хүнд хүртээмжтэй орчныг бий болгох зорилгоор DPUB төсөл “Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах семинар”-ыг зохион байгууллаа. Тус семинарт Барилгачдын нэгдсэн холбоо, Барилгын хөгжлийн төв, ХНХЯ, ТББ-уудын төлөөлөл гээд 70 гаруй хүн оролцсон бөгөөд шийдвэрлэх арга замын талаар ярилцлаа.



Семинарын үеэр

Гэтэл угаасаа барилгын зураг төсөлд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх талаар бүрэн тусгаагүй байдаг учраас барилга байгууламж хүртээмжтэй баригддаггүй гэдгийг ойлголоо. Мөн Барилга хүлээн авах комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл орсон байдаг хэдий ч анхнаасаа хүртээмжгүй баригдсан барилгыг засна гэдэг нь маш ярвигтай асуудал болоод байна. Иймээс барилгын зураг төсөлд хүртээмжийн асуудлыг тусгуулахын тулд Үнэлгээний хуудас боловсруулах хэрэгтэй гэсэн санал дэвшүүллээ. Энэхүү Үнэлгээний хуудсыг ашиглан зураг төслийн шатанд нь хүртээмжийн асуудлыг тусгаж, бэлэн болсон барилга байгууламжид ч гэсэн тус үнэлгээний хуудсын дагуу хяналт тавьснаар стандартад нийцсэн хүртээмжтэй орчныг бүрдүүлэх боломжтой болох юм. Улаанбаатар хотын хувьд хөгжиж буй хот учраас цаашид олон шинэ барилга байшин баригдах болно. Эдгээр шинэ барилга байгууламжийг хүртээмжтэй болгох, ХБИ, өндөр настан гээд бүх хүнд ээлтэй хотыг бий болгохын тулд одооноос “Түгээмэл загвар бүхий хот байгуулалт”-ыг бий болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

**Баян-Өлгий аймаг дахь
Хөгжлийн бэрхшээлийн статистик судалгаа
(2018.12.21)**

12-р сарын 10-ны өдрөөс Баян-Өлгий аймагт Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, NLM-Mongolia хамтран Хөгжлийн бэрхшээлийн статистик судалгааг зохион байгуулсан бөгөөд DPUB төсөл сургалт явуулан хамтран ажиллалаа.

Одоогийн байдлаар Монгол улсад эмнэлгийн загварт суурилсан хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээллийг л ашиглах боломжтой. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн агуулгат нийцүүлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн судалгааг явуулах хэрэгцээ бий. Хөгжлийн бэрхшээлийн статистик нь нэлээдгүй төвөгтэй асуудал ч ХБИ-ийн оролцоотойгоор цаашид сайжруулах шаардлагатай.

**Айлуудаар явж судалгаа
хийлээ**



**Монголын хөгжлийн бэрхшээлийн салбарын үйл ажиллагаа
CNN сувгаар цацагдлаа.**

Жил бүрийн 12/3-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр тохиодог. Хөгжлийн бэрхшээлийн салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааг төрөл бүрийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх нь чухал. 12/3~12/10 хүртэл Америкийн телевизийн суваг болох CNN-ээр Монголын Хөгжлийн бэрхшээлийн салбарын үйл ажиллагааны тухай сурталчилгаа цацагдсан байна.

Та бүхэн доорх линкээр орж үзээрэй.

<https://www.youtube.com/watch?v=qAVFzYR6NeQ>

MNC телевизийн "Ярилцах цаг" нэвтрүүлэгт DPUB төслийн мэргэжилтэн Тэрүя оролцлоо. Та бүхэн доорх линкээр орж үзнэ үү.

<https://www.facebook.com/mnctvchannel/videos/2081074868872353/>

**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж
нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **3682** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

<https://www.facebook.com/jicadpub/>

Хөгжлийн бэрхшээлийн мэргэжлийн мэдлэг

ESCAP-д 1 жил хагас ажиллахдаа надад хөгжлийн бэрхшээлийн мэргэжлийн мэдлэг чадвар дутагдаж байгааг хамгийн ихээр мэдэрч байлаа. Мэдээжийн хэрэг НҮБ-д хамгийн чадвартай, шилдэг мэргэжилтнүүд ажилладаг. Миний хувьд эхэндээ



Ахлах зөвлөх Чибэ

хурлын агуулгыг сайн ойлгохгүй, хааяа нэг миний саналыг асуухад учир нь ойлгогдохооргүй юм ярьдаг байлаа. НҮБ-ын туслах мэргэжилтэн байж иймэрхүү янзтай байж болохгүй хэмээн санаа зовж байсан боловч нөгөөтэйгүүр цаашид хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллах эсэхээ шийдээгүй байв. Тиймээс Тайландад ч гэсэн Олон улсын харилцааны чиглэлээр магистрантурт элсэн суралцангаа цаашид хэрхэхээ бодож байлаа. Яг тэр үед ESCAP-д ЖАЙКА-аас Бангкокт ХБИ-ийн төв шинээр барих ажлын төлөвлөгөө сонсогдож эхэлсэн. Эхэн үедээ ямар учиртай төв болохыг сайн ойлгоогүй боловч энэ нь ESCAP-аас хэрэгжүүлсэн “Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих 10 жил”-ийг үргэлжлүүлэх зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа байв. Тухайн үед би ЖАЙКА-ийн Далайн чанад дахь хамтын ажиллагааны сайн дурынхнаас өөр зүйлийн талаар мэдэхгүй байсан хэдий ч үйл ажиллагааны агуулгын талаар сонсоод бага багаар сонирхол төрж эхэлсэн юм. (Үргэлжлэл бий...)

DPUB Холбоо барих хаяг

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас:

<https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас:

<https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл:

dpub.jica@gmail.com